

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Аудитын сэдэв батлах” тухай 03 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөө болон Төв аймгийн Аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын ерөнхий дүгнэлт: Зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Аудитын нэр:

Авто замын хөрөнгө оруулалт, үр дүн



Аудитын код: YAG-ГАГ/2014/-02-ГА

**Зуунмод
2014 он**

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан Аудитын менежер О.Амаржаргал Шинжээч Ч.Загдсүрэн Аудитор О.Сосор Ж.Бямбацогт 2014 оны 10 дугаар сарын 20 Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.tuv-audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70273463 дугаарын утас, 70272582 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	Тайлангийн агуулга: Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт <i>БҮЛЭГ -1 Зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.</i> <i>Дүгнэлт 1.1 Гэрээгээр ажил эхлэсэн өдөр 60 хувийн ажлын гүйцэтгэл гаргаж, санхүүжилт авчээ</i> <i>Дүгнэлт 1.2 Зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ</i> <i>Дүгнэлт 1.3 Ажиллах хүч, техник тоног төхөөрөмжийн хувьд ажил гүйцэтгэх чадваргүй компанийг шалгаруулснаар замын ажил хийгдээгүй байна</i> <i>Дүгнэлт 1.4 Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан 311.2 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна</i> <i>Дүгнэлт 1.5 Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан компанитай шууд гэрээ байгуулж 134.9 сая төгрөгийн авто замын засварын ажил гүйцэтгүүлжээ</i> Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
--	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХБХГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
АЗЗА	Авто зам засвар арчлалт
ТАЗГ	Тээвэр авто замын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилт: Авто замын хөрөнгө оруулалт, түүний үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, олон нийтэд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

А. Авто замд хийгдсэн хөрөнгө оруулалт үр дүнтэй хийгдсэн үү?

1. Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын төсөл арга хэмжээний санхүүжилт бүрэн хийгдсэн үү?

2. Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын төсөл арга хэмжээний зураг, төсөв хийгдсэн үү?

3. Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын худалдан авах ажиллагаа нь хуулийн дагуу явагдсан уу?

4. Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын ажил бүрэн хийгдсэн үү?

5. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй авто замын засвар, шинэчлэлийн ажлууд хийгдсэн үү?

Аудитын хамрах хүрээ: Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Тээвэр авто замын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн замын сан, Худалдан авах ажиллагааны газрууд хамрагдан шалгагдлаа.

Үндсэн мэдээлэл: 2013 онд аймгийн авто замын засвар, шинэчлэлийн ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1443.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил эрх шилжиж, “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас 134.9 сая төгрөгийн, “Орон нутгийн авто замын сан”-гаас 333.3 сая төгрөгийн ажлууд хийгдсэн байна.

Эрсдлийн үнэлгээ: Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээ, ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдлийг “Дунд” гэж үнэлсэн.

Аудитын арга зүй: Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглана. Холбогдох хэлтсийн ажилтнуудтай ярилцлага хийж, санал асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль, тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2013 оны төсвийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТухай хууль
- Холбогдох бусад хууль, журам

Аудитын хугацаа: Аудитыг 2014 оны 10 дугаар сарын 01-нд эхлэж, 10 дугаар сарын 17-нд дуусгаж, ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хүргүүлнэ.

Аудит хийх бүрэлдэхүүн: Аудитыг аймгийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал удирдан, шинжээч Ч.Загдсүрэн, аудитор Ж.Бямбацогт, О.Сосор нар гүйцэтгэв.

Авто замд хийгдсэн хөрөнгө оруулалт үр дүнтэй хийгдсэн үү?

Бүлэг 1

Зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

1.1 Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжигдэж буй авто замын төсөл арга хэмжээний санхүүжилт бүрэн хийгдсэн үү?

Гэрээгээр ажил эхлэсэн өдөр 60 хувийн ажлын гүйцэтгэл гаргаж, санхүүжилт авчээ.

2013 онд аймгийн авто замын засвар, шинэчлэлийн ажилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1443.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил эрх шилжиж, “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас 134.9 сая төгрөгийн, “Орон нутгийн авто замын сан”-гаас 333.3 сая төгрөгийн ажлууд хийгдсэн байна.

Зам тээврийн яамны сайдын багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1443.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажил орон нутагт эрх шилжиж хийгджээ. Үүнд :

№	Авто замд хийгдэх ажлууд	Төсөвт өртөг	Батлагдсан хөрөнгийн эх үүсвэр	Гэрээний дүн
1	Төв аймгийн Зуунмод сумын А25 чиглэлийн авто замаас цэнгэлдэх хүрээлэнгийн 4 замын уулзвар хүртэлх 1.6 км хатуу хучилттай авто замын барилгын ажил	943,893,967	887,800,000	887,759,822
2	1,5 км автозамын шинэчлэлийн ажлын дуусгал / Төв Баян хошуу баг/	369,166,206	317,000,000	311,248,894
3	Туул голын модон гүүрний засвар /Төв Алтанбулаг/ Улсын төсвөөс 100 сая, ОНТ 30.9 сая	130,600,000	100,000,000	130,116,995
		1,443,660,173	1,304,800,000	1,329,125,711

Эдгээр ажлуудад “Монгол улсын 2013 оны төсвийн тухай хууль”-аар нийт 1304.8 сая төгрөг батлагдаж 1021.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Зуунмод сумын А25 чиглэлийн авто замаас цэнгэлдэх хүрээлэнгийн 4 замын уулзвар хүртэлх 1.6 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг “Экспресс зам” ХХК хугацаанд нь гүйцэтгэж, санхүүжилт бүрэн авсан боловч Зам тээврийн яамнаас 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү шилжүүлсэн зөрчил илэрч төлбөрийн акт бичигдлээ. Мөн Баянхошуу багийн 1.5 км автозамын шинэчлэлийн

ажлын гүйцэтгэл 22 хувьтай, 67.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, ажлаа дуусгаагүйгээс 244.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна. Туул голын модон гүүрийн засварын ажил нь улсын төсвийн хөрөнгөөр 100.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 30.9 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр хөрөнгийн эх үүсвэр батлагдаж, 2013 оны 12 сарын 25-ны өдөр ажил эхлэхээр гэрээ байгуулжээ. Гэвч ажил эхлэсэн өдөр буюу 2013 оны 12 сарын 25-нд ажлын гүйцэтгэлийг 60 хувиар гаргаж, 75.8 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ. Уг ажлыг 2014 оны 05 сарын 28-ны өдөр ажил хүлээлцэх комиссын актаар хүлээж авсан боловч улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх 22.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүй байна.

1.2 Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын төсөл арга хэмжээний зураг, төсөв хийгдсэн үү?

Зураг төсөв хийгдээгүй ажилд хөрөнгө батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй авто замын ажлуудын зураг төсөв батлагдаагүй байхад хөрөнгийг батлуулснаас санхүүжилт нь батлагдсан ажлын тоо хэмжээ болон төсөвт өртөг нь зураг төсвөөс зөрүүтэй болсон байна.

Аймгийн төвийн А25 кодтой замаас эмнэлгийн 4 замын уулзвар хүртэлх 1.6 км зам, Баянхошуу багийн 1.5 км авто замын ажлуудын зураг төсвийг 2012 оны 07 сарын 19-ны өдөр аймгийн Засаг дарга, “Дөрвөн тэнхлэг” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээгээр 2012 оны 07 сарын 20-ноос 2012 оны 08 сарын 20-ны өдрийн дотор хийж дуусгахаар байсан боловч гэрээний хугацаа хэтэрч 2013 оны 04 сарын 22-ны өдөр “Барилгын хөгжлийн төв”-өөс хянан баталгаажуулж, 2013 оны 05 сарын 01-ны өдөр актаар хүлээж авчээ.



А25 кодтой зам



Баянхошуу багийн зам

Зураг төсөв хийх явцад А25 кодтой замаас эмнэлгийн 4 замын уулзвар хүртэлх 1.6 км зам нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн замын уулзвар биш цэнгэлдэх

хүрээлэнгийн замын уулзвар хүртэлх 943.8 сая төгрөгийн өртөгтэй 1.49 км зам, Баянхошуу багийн 1.5 км автозамын шинэчлэлийн 317.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй авто зам нь 1.3 км 369.2 сая төгрөгийн өртөгтэй зам болж ажлын хэмжээ болон төсөвт өртөг өөрчлөгдсөн байна. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 29.3-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтыг зөрчин зураг төсөв нь батлагдаагүй ажилд хөрөнгийн эх үүсвэр батлуулснаас болжээ.

1.3 Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын ажлын худалдан авах ажиллагаа нь хуулийн дагуу явагдсан уу?

Ажиллах хүч, техник тоног төхөөрөмжийн хувьд ажил гүйцэтгэх чадваргүй компанийг шалгаруулснаар замын ажил хийгдээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 1304.8 сая төгрөгийн авто зам засварын 3 ажлыг гүйцэтгүүлэхээр нээлттэй тендер шалгаруулалтыг явуулжээ. Үүнээс хоёр авто замын шинэчлэл засварын 987.8 сая төгрөгийн ажил бүрэн хийгдэж, 311.2 сая төгрөгийн нэг ажил хийгдээгүй байна.

Зам тээврийн яамны сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн Зуунмод сумын Баянхошуу багийн 1.5 км авто замын барилгын ажилд 317.0 сая төгрөг батлагджээ. Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар “Гиацинт” ХХК шалгарч, 311.2 сая төгрөгөөр 2013 оны 6 сарын 20-ноос 2013 оны 7 сарын 20-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж, ажил дуусгах өдөр буюу 2013 оны 07 сарын 20-ны өдөр 22.1 хувийн ажлын гүйцэтгэл гаргаж, 67.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Гэвч өнөөдрийн байдлаар нэмж ажил хийгдээгүй, өмнө хийсэн ажил буюу 67.1 сая төгрөгийн засварын ажил байхгүй болж, зам эвдэрч, өмнө зарцуулагдсан хөрөнгө оруулалтын үр дүн байхгүй болжээ. Энэ нь ажиллах хүч, техник тоног төхөөрөмжийн хувьд ажил гүйцэтгэх чадваргүй компанийг шалгаруулсантай холбоотой юм.



Баянхошуу багийн зам

1.4 Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж буй авто замын ажил бүрэн хийгдсэн үү?

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан 311.2 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.

2013 онд аймгийн авто замын шинэчлэлийн ажилд 1304.8 сая төгрөг батлагдаж замын ажлууд хийгдсэн боловч 311.2 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.

Зам тээврийн яамны сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төв аймгийн төвийн А25 кодтой замаас эмнэлгийн 4 замын уулзвар хүртэл 1.6 км авто замыг хийхэд 943.8 сая төгрөг батлагджээ. Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтаар “Экспресс зам” ХХК нь 887.8 сая төгрөгөөр 2013 оны 6 сарын 19-нөөс 2013 оны 7 сарын 20-ны дотор хийхээр гэрээ байгуулж хугацаанд нь хийж гүйцэтгэн “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт”-аар хүлээж авсан байна.

Баян хошуу багийн 1.3 км автозамын шинэчлэлийн ажил хийгдээгүй шалтгаан нь гүйцэтгэгч компанийн ажиллах хүч, техник тоног төхөөрөмж ажил гүйцэтгэх чадваргүйгээс ажил зогссон болох нь Тээвэр авто замын газрын мэргэжилтнээс авсан тодруулга, газар дээр нь очиж шалгахад хийсэн ажлаар нотлогдож байна.

Туул голын модон гүүрийн засварын ажлыг гүйцэтгэгч “Ойл рөүд” ХХК нь гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй байна. Тус компани нь аймгийн Тээвэр, авто замын газарт 2014 оны 01 сарын 24-ний өдөр “цаг агаарын байдал дулаан байгаагаас мөсөн дээгүүр ус хальж ажилд хүндрэлтэй байгаа учир ажил хүлээлгэн өгөх хугацааг тодорхой хэмжээгээр сунгаж өгөх”-ийг хүссэн хүсэлтийг гаргаж, гэрээгээр 2014 оны 01 сарын 30-ны өдөр хүлээлгэж өгөх байсан боловч 2014 оны 03 сарын 07-ны өдөр ажил хүлээн авах комисс ажиллуулж өгөх хүсэлтийг аймгийн Тээвэр, авто замын газарт ирүүлж 2014 оны 05 сарын 28-ны өдөр комисс актаар хүлээж авсан байна.



Туул голын модон гүүр

1.5 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар авто замын засвар, шинэчлэлийн ажлууд хийгдсэн үү?

Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан компанитай шууд гэрээ байгуулж 134.9 сая төгрөгийн авто замын засварын ажил гүйцэтгүүлжээ.

2013 онд “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас 134.9 сая төгрөгийн, “Орон нутгийн замын сан”-гаас 333.2 сая төгрөгийн, нийт 468.1 сая төгрөгийн авто замын засвар, шинэчлэлийн ажлуудыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэжээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12 сарын 14 –ний өдрийн 02 дугаар хуралдааны 05 тоот тогтоолоор Төв аймгийн орон нутгийн замын сангаас 2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг баталсан байна.

2013 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалт /мян.төг/

№	төсөл, арга хэмжээний нэр хүчин чадлын хэмжээ	төсөвт өртөг
1	Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын засвар	67984.1
2	Зуунмод сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талын хатуу хучилттай замын авто засвар, шинэчлэлийн ажил	162977.2
3	Эрдэнэсант сумын төвийн хайрган хучилттай авто замын засвар	49938.4
4	Сумдын зам талбайг тэмдэгжүүлэх	12988.0
5	Орон нутгийн замын сангийн хөрөнгө төвлөрүүлэх	5000.0
6	Зуунмод сумын хатуу хучилттай замын өвөл, зуны арчлалт	15000.0
7	2014 онд хийгдэх авто замын ажлын зураг төсвийн үнэ	19362.3
	дүн	333250.0

Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын засварын ажлыг гүйцэтгэхээр харьцуулалтын аргаар тендерт шалгарсан Баткубик ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай ТАЗГ-ын 2013 оны 05-р сарын 31 ны өдрийн 66 тоотыг хүргүүлсэн байна. Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын засварын ажлыг 67800.7 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэхээр Баткубик ХХК нь 2013 оны 06 сарын 20 ны өдөр гэрээг байгуулсан байна. Баткубик ХХК нь засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 2013 оны 07-р сарын 03-ны өдөр дуусгажээ. ТАЗГ-ын даргын 2013 оны 10 сарын 02-ны өдрийн 22 тоот тушаалаар Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын засварын ажлыг хүлээн авах комиссыг 5 хүний бүрэлдхүүнтэй томилсон байна. Дээрхи комиссууд 2013 оны 10 сарын 02-ны өдөр зам засварын ажлыг хүлээн авч барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт үйлдэн комиссоос зураг төсвийн дагуу бүрэн хийгдэж, “авто машины хөдөлгөөн нэвтрүүлэх зориулалтаар ашиглахад шаардлага хангаж байна” гэж дүгнэсэн байна. Орон нутгийн Замын сангаас Зуунмод сумын төвийн хатуу хучилттай авто замын засварын ажлын гүйцэтгэлийг үндэслэн 66.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Зуунмод сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талын хатуу хучилттай замын авто засвар, шинэчлэлийн ажлыг 152.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр Баткубик ХХК нь 2013 оны 06 сарын 20- ны өдөр гэрээг байгуулсан байна. Баткубик ХХК нь засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 2013 оны 07-р сарын 20 ны өдөр

дуусгасан байна.ТАЗГ-ын 2013 оны 10 сарын 02-ны өдрийн 23 тоот тушаалаар Зуунмод сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талын хатуу хучилттай замын авто засвар, шинэчлэлийн ажлыг хүлээн авах комиссыг 5 хүний бүрэлдхүүнтэй томилсон байна. Дээрхи комиссууд 2013 оны 10 сарын 02-ны өдөр зам засварын ажлыг хүлээн авч барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт үйлдэн комиссоос зураг төсвийн дагуу бүрэн хийгдэж авто машины хөдөлгөөн нэвтрүүлэх зориулалтаар ашиглахад шаардлага хангаж байна гэж үзээд захиалагч /ашиглагч/ ТАЗГ-ын мэдэлд 2013 оны 10 сарын 02-ны өдрөөс ашиглалтанд оруулахыг зөвшөөрсөн байна. Орон нутгийн Замын сангаас Зуунмод сумын Цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талын хатуу хучилттай замын авто засвар, шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн 148.8 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангаас 14.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

“Орон нутгийн хөгжлийн сан”-гийн 134.9 сая төгрөгийн хөрөнгөөр Зуунмод сумын соёл, амралтын хүрээлэнгийн зүүн талын авто зогсоолын ажлыг шинээр хийж гүйцэтгэжээ. Уг ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахдаа ГХБХГазар нь ажил гүйцэтгэх хугацаа “богино” гэдэг шалтгаанаар тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан “Төв АЗЗА” ХК-тай шууд гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн зам засварын ажил гүйцэтгэх зарим компани нь ажлаа хийж эхлээгүй байхад гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан, зарим ажлууд нь хийгдээгүй учраас батлагдсан хөрөнгө оруулалт тухайн ондоо олгогдоогүй байна.
2. Авто замын хөрөнгө оруулалтын зураг, төсөв хийгдээгүй байхад хөрөнгийн эх үүсвэрийг батлуулсан байна.
3. Тендер шалгаруулалтаар тендерт оролцогч компаниудын ажил гүйцэтгэх чадварыг үнэлж чадаагүйгээс ажил гүйцэтгэх чадваргүй компанийг шалгаруулжээ.
4. Ажил гүйцэтгэх чадваргүй компанийг шалгаруулснаар тухайн онд батлагдсан замын ажил хийгдээгүй байна.
5. Худалдан авах ажиллагааг хугацаанд нь явуулаагүйгээс шууд гэрээ байгуулж ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчжээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн аймгийн ГХБХБГазарт зөвлөх нь:

1. Зураг төсөв нь хийгдсэн ажилд хөрөнгө батлуулах

Аймгийн Худалдан авах ажиллагааны албанд зөвлөх нь:

1. Худалдан авах ажиллагааг зөв төлөвлөж, хугацаанд нь хуулийн дагуу явуулах

Аймгийн ТАЗГазарт зөвлөх нь:

1. Ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгох
2. Тухайн онд батлагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгүүлэх

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал